



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

173 /173/

2021.11.09

ЦАГ ҮЕ, ҮЙЛ ЯВДАЛ

АЖЛЫН ХЭСЭГ ЗҮҮН БҮСИЙН АЙМГУУДАД ...



Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбаруудыг орчин үеийн стандартын шаардлага хангасан хэв маяг, инженерийн шийдэл бүхий жишиг "Цэргийн хотхон" болгох төсөл шат дараатайгаар хэрэгжиж байгаа билээ. Уг төсөлтэй уялдуулан Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнайгаар ахлуулсан ажлын хэсэг өнгөрөгч оны 10 дугаар сард баруун бүсийн аймгуудад байрлах Зэвсэгт хүчний анги, салбаруудтай танилцаж тэдгээрт тулгамдаж буй асуудлуудыг тодорхой хэмжээнд шийдвэрлэж ажилласан.

Тэгвэл дээрх ажлын хэсэг энэ сарын 8-14-ний өдрүүдэд зүүн бүсийн аймгуудад байрлах Зэвсэгт хүчний анги, салбаруудад ажиллаж тэдгээрийн үйл ажиллагаа, офицер, ахлагч, ажилтан албан хаагчдын ахуйн нөхцөл байдал, нийгмийн хамгаалал, хугацаат цэргийн алба хаагчдын амьдрах орчин болон барилга байгууламжийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудалтай танилцаж байна. Ажлын хэсэг өчигдөр ард түмнийхээ дунд "Төрийн торгон сүргийн анги" хэмээн нэрлэгдсэн Зэвсэгт хүчний

232 дугаар ангид ажилласан бөгөөд тус ангийн захирагч, хурандаа Н.Мягмарцоож ажлын хэсгийг угтан авч ангийнхаа үйл ажиллагааны талаар товч танилцуулга хийлээ. Үүний дараа ажлын хэсгийн бүрэлдэхүүн тус ангийн барилга байгууламж, орчин нөхцөл, хугацаат цэргийн алба хаагчдын сургалт бэлтгэлийн явц, дотоод нөөц боломждоо тулгуурлан хийж бүтээсэн ажлууд, тулгамдаж буй асуудлуудтай танилцлаа. Энэ үеэр тус ангийн захирагч, хурандаа Н.Мягмарцоож

ангийн үндсэн үүргийн нэг болох Улаанбаатар цэргийн хүрээний ангиудыг эрүүл мах, махан бүтээгдэхүүнээр хангахад мах боловсруулах стандарт бүхий камбениат, спорт заалтай болох зайлшгүй шаардлагатай байгаагаа хэлсэн юм. Харин ажлын хэсгийнхэн эдгээр болон бусад тулгамдсан асуудлыг ойрын хугацаанд шийдвэрлэж өгөхөө онцоллоо. Ажлын хэсэг өнөөдөр Зэвсэгт хүчний 327 дугаар ангид ажиллаж байна.

Дэслэгч О.ТӨРТОГТОХ

Хилийн чанадаас

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН АЖИЛЛАГААНЫ ГАЗАР ОРОНД АЖИЛЛАВ



мужийн хариуцлагын бүсэд цагийн байдлын ямар ч нөхцөлд энх тайван, тогтвортой байдлыг хангахад Монголын батальоны оруулсан хувь нэмэр, хүчин чармайлт хэмжээлшгүй их төдийгүй монгол цэрэг мэргэжлийн ур чадвар, үүрэг гүйцэтгэлтээрээ хамгийн шилдэг нь байсаар ирсэн" хэмээн онцолж, Монгол Улсын Засгийн газар, Монгол Улсын Зэвсэгт хүчний удирдлагад талархаж байгаагаа илэрхийлсэн юм.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн цэргийн багийн хариуцлагын бүс дэх "Хубилай", "Арвай", "Дельта", "Эко" баазуудын үйл ажиллагаа, цэргийн алба хаагчдын үүрэг гүйцэтгэлт, ажиллаж, амьдарч буй орчин нөхцөл, зэвсэглэл, техниктэй танилцаж, бие бүрэлдэхүүнд холбогдох үүрэг, чиглэл өгөөд эх орныхоо зүг хөлгийн жолоо залсан юм.

Ахлах дэслэгч Г.ЦЭРЭННАМИД



БНӨСУ-д явагдаж буй НҮБ-ын мандаттай "UNMISS" энхийг дэмжих ажиллагааны газар оронд Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн багууд солигдож байгаа билээ. Монгол Улсын Батлан хамгаалахын сайдын тушаалаар ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын дарга, бригадын генерал С.Дашзэвгээр ахлуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн цэргийн багуудын ээлжийг хүлээлцүүлэх, ажиллагааны газар оронд батальоны үүрэг гүйцэтгэлт, үйл ажиллагаатай танилцах, харилцан ажиллагааг зохион байгуулах зорилгоор өнгөрөгч сарын 27-ны өдрөөс энэ сарын 4-ний өдрүүдэд батальоны дөрвөн баазад ажиллалаа.

Мөн ажлын хэсгийн бүрэлдэхүүн Юнити секторын ерөнхий зохицуулагч хатагтай Хироко Хирохара болон Юнити секторын командлагч, бригадын генерал ДМ Шамим Камал нартай уулзалт зохион байгуулсан юм. Уулзалтын үеэр хатагтай Хироко Хирохара хэлсэн үгэндээ "Юнити

Түүхэнд энэ өдөр

1964 он.

Нийслэл хотыг агаараас халхлах зенит пуужингийн зэвсэглэлийг Зөвлөлтийн мэргэжилтнүүдээс хүлээн авсан актад гарын үсэг зурав.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
1	-15

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
35	23

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,850.0	2,853.0
EUR	3,305.0	3,315.0
CNY	445.50	446.50
RUB	40.40	41.00
JPY	25.05	25.30
KRW	2.39	2.40

ЗУРХАЙ

2021.11.09 МЯГМАР ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 05/

ӨВЛИЙН ТЭРГҮҮН ШАРАГЧИН ГАХАЙ САРЫН НЭГ ЦАГААН ЦАГААГЧИН ТАХИА ӨДӨР

Үс засуулбал:

Эд, мал арвижна.

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

07.49-17.23

БАРИЛДЛАГА:

Үхэх

ШҮТЭН БАРИЛДЛАГА:

Тийн мэдэхүй

Суудал:

Шороо

Аргын тооллын 11 сарын 9, Ангараг гараг. Билгийн тооллын 5, Суулга одтой, цагаагчин тахиа өдөр. Өдрийн наран 7 цаг 49 минутад мандан, 17 цаг 23 минутад жаргана. Тухайн өдөр үхэр, могой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамаг хандаж, бие энхрийлүүштэй. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адгуус муулах, хагалгаа хийлгэх, буг дарах, газрын ам бооход сайн. Мод суулгах, нарийн чанд зөвлөгөөн хийх, байшингийн суурь тавих, угаал үйлдэхэд муу. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой.

Хол газар яваар одогсод баруун зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эд, мал арвидна.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН 357,977 +450	ЭДГЭРСЭН 536,192	НАС БАРСАН 1,665 +8
----------------------------------	---------------------	------------------------

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 6218 +106	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 160	ЭДГЭРСЭН 5937
------------------------------	----------------------------	------------------

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 250,999,064
Эдгэрсэн Нийт: 227,248,387
Нас барсан Нийт: 5,070,333

Мэдээ, мэдээлэл

ЭНХИЙГ САХИУЛАГЧИД ЭХ ОРОНДОО ИРЛЭЭ



Бүгд Найрамдах Өмнөд Судан Улсад явагдаж буй НҮБ-ын мандаттай "UNMISS" ажиллагаанд үүргээ нэр төртэй гүйцэтгэсэн Монгол Улсын Зэвсэгт хүчний 10 дугаар ээлжийн цэргийн багийн 2 дугаар цувааны бие бүрэлдэхүүн өчигдөр эх орондоо хүрэлцэн ирлээ.

БАЙНГЫН БҮРЭЛДЭХҮҮН ӨВЛИЙН ХУВЦСАНД ШИЛЖЛЭЭ

ЗХЖШ-ын даргын 2021 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн А/619 дүгээр тушаалаар Зэвсэгт хүчний генерал, офицер, ахлагч нарыг энэ сарын 8-ны өдрөөс хүйтний улирлын дүрэмт хувцсанд шилжүүлэв.

"МИНИЙ ЭР ЗОРИГ" СЭДЭВТ ЭСЭЭ БИЧЛЭГИЙН УРАЛДААН ЗАРЛАГДАНА

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийг баталсан. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Эх оронч залуу" аяныг жил бүр уламжлал болгон зохион байгуулж байгаа билээ. Тэгвэл энэ жил Монгол Улсад залуучуудын байгууллага үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойтой холбогдуулан




зохион байгуулж байгаа юм. Энэ удаа бид Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын сургагч багш нарыг бэлтгэж байна. Сургагч багш нар маань өөрсдийн нэгтгэл, ангидаа тус хөтөлбөрийн сургалтыг үргэлжлүүлэн явуулсны араас "Миний эр зориг" сэдэвт эсээ бичлэгийн уралдааныг албан ёсоор эхлүүлнэ. Үндэсний хэмжээнд хэрэгжиж буй энэ хөтөлбөрөөс шалгарсан шилдэг таван эсээг англи хэл дээр хөрвүүлэн олон улсын томоохон уралдаануудад илгээнэ. Манай орны цэргийн алба хаагчид эх орноо хамгаалах их үйлсийн эзэд болдогос гадна дэлхийн халуун цэгүүдэд энхийг дэмжих ажиллагаанд оролцдог. Тиймээс батлан хамгаалах салбараас энэ уралдааны хүчтэй өрсөлдөгчид төрөн гарна гэдэгт бид итгэлтэй байна" гэлээ.

тус аяныг илүү өргөн хүрээнд зохион байгуулж байгаагийн нэгэн хэлбэр нь батлан хамгаалах салбартай хамтран Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын төлөөллүүдэд хувь хүний хөгжлийн талаар болон "Мах courage" буюу өөрийн эр зоригийн түүхээрээ эсээ

бичих чадвар эзэмшүүлэх олон улсын хөтөлбөрийн сургалтыг өчигдөр зохион байгууллаа. Энэ үеэр Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын мэргэжилтэн У.Долгормаа "Тус хөтөлбөрийг бид анх удаа үндэсний хэмжээнд

"ХХИ ЗУУНЫ ДИЖИТАЛ ТЕХНОЛОГИ БА ИХ СУРГУУЛИЙН БАГШ" ЦАХИМ СУРГАЛТАД ҮБХИС-ИЙН БАГШ НАР ХАМРАГДЛАА



2021 оны 10 дугаар сарын 27-29-ний өдрүүдэд Microsoft Teams болон Edx.edu. mn платформуудаар цахим хэлбэрээр амжилттай зохион байгуулагдсан.

Энэхүү семинар сургалтад Монгол Улсын төрийн болон төрийн бус өмчийн 44 их, дээд сургуулийн 179 багш хамрагдаж батламж гардан авахаар боллоо. Тус сургалт нь дээд боловсролын сургалтын байгууллагын багш нарт "Дижитал технологи дээд боловсролын багш", "Сургалтын дизайн ба цахим сургалтын технологи", "Цахим контент ба сургалтын нээлттэй нөөц материал", "Дижитал профессор ба дижитал оюутан", "Нийтэд зориулсан нээлттэй онлайн хичээл" гэсэн агуулгуудын хүрээнд багш нарын мэргэшлийн үр чадварт нь дэмжлэг үзүүлэхэд чиглэснээрээ онцлог байв.

БШУЯ-ны харьяа Багшийн мэргэжил дээшлүүлэх институтын Дээд боловсролын багшийн хөгжлийн албанаас ШУТИС-ийн Нээлттэй боловсролын төвтэй хамтран их, дээд сургуулийн багш нарт зориулан "ХХИ зууны дижитал технологи ба их сургуулийн багш" сэдэвт 5 модуль сургалт

30 КМ-ИЙН ЯВГАН МАРШИЙГ ҮЙЛДЛЭЭ



Ангийн 2021-2022 оны сургуулийн жилийн сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу тактик, тусгай бэлтгэлийн 30 км-ийн явган маршийг ангийн офицер, ахлагч нарын гар нийлэмжтэй ажиллагааг хангах, цаг агаарын хүндрүүлсэн нөхцөлд байлдааны болон олон талт үүрэг гүйцэтгэх үеийн сэтгэл зүйн бэлтгэлжилтийн түвшнийг дээшлүүлэх, мэдлэг, дадлага, үр чадварыг хөгжүүлэх зорилгоор өнгөрөгч 10 дугаар сарын 29-ний өдөр зохион байгууллаа. Тактик, тусгай бэлтгэлийн 30 км-ийн явган маршийг ангийн байрлал-Радиолокаторын пост 1-ҮБХИС-ийн хээрийн полигон-ангийн байрлал гэсэн маршрутаар үйлдсэн юм.

Маршийн удирдагчаар захирагчийн орлогч, захиргааны удирдлагын тасгийн дарга, дэд хурандаа Г.Баатархүү, маршийн удирдагчийн туслахаар ажиллагааны офицер, хошууч Б.Мөнхболд, дундын хянагчаар зэвсгийн офицер, хошууч Ц.Хишигжаргал, соёл хүмүүжлийн офицер,

ахмад З.Анхбаяр, тусгай бэлтгэлийн багш, ахмад А.Волга, эмчээр Б.Оюунчимэг нар үүрэг гүйцэтгэв.

Ангийн нийт бие бүрэлдэхүүн 05.50 цагт "Цугларалт" дохиогоор ажиллаж, маршийн удирдагч, дэд хурандаа Г.Баатархүү ангийн захирагчийн тушаал, маршийн төлөвлөгөө, маршрутыг танилцуулж, хүн нэг бүрийн хувийн зэвсэг, хамгаалах хэрэгслэл, офицер цүнх, аранзтайгаар 08.30 цагт хөдөлгөөн үйлдэж, 11.00 цагт ҮБХИС-ийн хээрийн полигоны баруун урд химийн цагийн байдал, газрын дайралт хийж бие бүрэлдэхүүний бэлтгэлжилтийн түвшнийг шалгалаа. Мөн ҮБХИС-ийн хээрийн полигоны зүүн урд түр амралтыг зохион байгуулж, хүн нэг бүрийн зэвсэгт үзлэг хийж, аранзны хүнсээр хооллолтыг зохион байгуулсан бөгөөд төлөвлөгөөний дагуу 12.30 цагт хөдөлгөөн үйлдэж 14.30 цагт ангийн байрлалд ирэв.

Ахмад З.АНХБАЯР



"ЦЭВЭР АГААР-ЭРҮҮЛ УУШГИ" УРИАТАЙГААР ...



зүйн байдлыг дээшлүүлэх зорилгоор зохион байгууллаа. Ангийн Эмэгтэйчүүдийн зөвлөлтэй хамтран зохион байгуулсан уг аяллаар бие бүрэлдэхүүн 4 бүлэгт хуваагдаж "Аяны хоол шалгаруулах", "АХА", "Хөгжөөнт буухиа", "Гар барилдаан" зэрэг тэмцээнүүдээр хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөн юм.

Зэвсэгт хүчний 284 дүгээр анги 2021-2022 оны сургуулийн жилийн цэргийн сургалт, бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу "Цэвэр агаар-Эрүүл уушги" уриатайгаар 30 км-ийн явган маршийг бие бүрэлдэхүүний чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хамт олонч байдлыг нэмэгдүүлэх, дархлаа дэмжих, сэтгэл



Цэргийн төв эмнэлэг-100

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ ИРГЭД ХҮЛЭЭН АВЧ ЭХЭЛЛЭЭ

Цэргийн төв эмнэлэг 2020 оны 2 дугаар сарын 28-наас хойш коронавируст цар тахалтай тэмцэхтэй холбогдуулан үйл ажиллагаагаа түр зогсоогоод байсан. Энэ хугацаанд 6 мянга гаруй батлагдсан тохиолдлыг авч эмчлэн, 1600 орчим тусгаарлалтын ажлыг зохион байгуулж, эмнэлгийн тусламж үйлчилгээг 24 чиглэлээр

үзүүлжээ. Тэгвэл эмнэлгийн үндсэн үйл ажиллагаа болох хэвтэн эмчлүүлэх хэсэг буюу /стационар/ амбулаторийн үзлэг, үйлчилгээ өнгөрсөн сарын 25-ны өдрөөс хэвийн явагдаж эхэлсэн бөгөөд иргэд 11450097 дугаарын утсаар холбогдон үзлэг, үйлчилгээний талаарх шаардлагатай мэдээллийг авах боломжтой ажээ.



Дарга, ерөнхий редактор, хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ



ЦАХИМ ХАЯГ

Батлан хамгаалах яам
Зэвсэгт хүчний Жанжин штаб



ЦАХИМ ХУУДАС

"Соёмбо" сонин
"Дуулга" студи

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
* Тус сонин мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс: 10018

Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn Утас: 70001029, 3412 (дотуур)